



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 22 өдөр

Дугаар A/79

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.6, “Хяналт шалгалтын журам”-ын 13 дугаар зүйлийн 13.1.1.13 дахь заалт, Хяналт, шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн гишүүн “Гаүли ҮЦК” ХХК-ийн брокер Ц.Чанцал нь үнэт цаасны арилжааны трейдэр программ хангамжид нэвтрэх нэр, нууц үгийг тус компанийн шинжээч Ж.Мөнхбаатарт дамжуулж, ажлын хариуцлага алдсан тул Ц.Чанцалын арилжаанд оролцох эрхийг түдгэлзүүлсүгэй.
2. “Гаүли ҮЦК” ХХК-иас арилжаанд оролцох эрх нь түдгэлзсэн ажилтны гаргасан зөрчлийг бүрэн арилгасан тухай мэдэгдэлийн дагуу зохих шалгалтыг хийж, зөрчил арилсан нь тогтоогдсон тохиолдолд арилжаанд оролцох эрхийг сэргээгдсэнд тооцсугай.
3. Арилжаанд оролцох эрх нь түдгэлзсэн ажилтны гаргасан зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газар /А.Мөнхбаясгалан/-т даалгасугай.
4. Цаашид үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг, алдааг давтан гаргасан тохиолдолд шат дараалсан арга хэмжээ авахыг “Гаүли ҮЦК” ХХК-ийн захирал /Хан Гю Бун/, брокер /Ц.Чанцал/ нарт хатуу анхааруулсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000275